65	2.3.1.1.2 "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах	-		38	44	2025 оны хагас жилийн байдлаар "Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд орон нутгийн 17 сургууль, 34 цэцэрлэг тогтмол шүд угаах цагийг бий болгон хэвшүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2025 оны 1 дүгээр сард багш, ажилчдын санаачилгаар Хэрлэн 5-р сургууль, Хан Хэнтий цогцолбор сургууль, Тэмүүжин цогцолбор сургууль шүд угаах орчныг сайжруулах, тохижуулах ажлыг өөрсдийн нөөц боломжоор хийж хэрэгжүүлсэн нь үлгэр жишээ болохуйц сайн туршлага болсон. "24/3 – Шүдээ зөв угаа" аяны хүрээнд ЕБС-ийн 35 бүлгийн 1,247 сурагчид	100

					хамрагдсан бөгөөд эдгээр хүүхдүүдэд “Амны хөндийн эрүүл мэнд” сэдвийн хүрээнд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн цахим мэдээллийн сувгуудыг ашиглан 23,690 иргэн, олон нийтэд амны хөндийн өвчнөөс сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэж, сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион ажиллаа. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “6 настнуудын нүд, шүд, зүрхний өвчний эрт илрүүлэг” үзлэгийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 1,688 хүүхэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж буй бөгөөд 2025 оны хагас жилийн байдлаар 832 хүүхэд буюу 49.2% нь хамрагдаад байна. Эдгээр ажлууд нь хүүхдийн амны хөндийн өвчлөлийг бууруулах, зөв дадал хэвшил төлөвшүүлэх, эрт илрүүлэг хийх замаар ирээдүйн эрүүл мэндэд оруулах хөрөнгө оруулалт болох чухал ач холбогдолтой хэрэгжиж байна.		
66	2.3.1.1.3 Зорилтот бүлгийн хүн амд халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	5.0		60	65	Хэнтий аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 5 чиглэлийн арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүллээ. Үүнд: “Осол гэмтлээс сэргийлэх – 0-5 насны хүүхдийн аюулгүй орчин” сарын аян “Хорт хавдрын эсрэг анхаарал хандуулах” сарын аян, “Дархлаажуулалтын 10 хоног”, “Дэлхийн тамхигүй өдөр”, “24/3	100

					<p>– Шүдээ зөв угаа” сарын аян Эдгээр аяны хүрээнд нийт 6 сэдвээр иргэд, олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулсан. Иргэдэд зориулсан 47 удаагийн танхимын сургалт Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 192 удаагийн танхимын сургалт зохион байгуулагдсан. Энэхүү сургалт, мэдээлэлд: Насан хүрэгчдийн 3,991 иргэн, өсвөр насны 3,462 хүүхэд хамрагдаж, нийтдээ 7,453 иргэн, эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл хүргэн ажиллаа. Мөн цахим хуудсаар дамжуулан дунджаар 17,044 иргэн, олон нийт эрүүл мэндийн мэдээлэл авсан байна. Хэнтий аймгийн зорилтот бүлгийн иргэдийн 33.1%-ийг хамарсан үзүүлэлттэй байна. Эдгээр арга хэмжээ нь хүн амын эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг сайжруулах, урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Иргэдэд сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.</p>	
67	2.3.1.1.4 "Эрүүл монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	-	90	<p>“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 5 чиглэлээр нийт 192 удаагийн танхимын сургалт зохион байгууллаа. Эдгээр сургалтаар дамжуулан зорилтот бүлгийн 7,453 иргэн,</p>	70

					олон нийтийг хамруулж, эрүүл мэндийн боловсролыг түгээн ажилласан байна. Хагас жилийн байдлаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 30.2%-ийн гүйцэтгэлтэй байна.		
68	2.3.1.1.5 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулж, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх	15.0		Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт-85 БЗДХ-ын эмчилгээний хамрагдалт-80%-тай байна.	Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт-87 БЗДХ-ын эмчилгээний хамрагдалт-82	Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ болон бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 663 иргэдийг хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд шинээр сүрьеэгийн өвчлөл 20, БЗДХ-ын 46 тохиолдол илрэн, тус иргэдийг эмчилгээ хяналтад бүрэн хамруулсан. Мөн сүрьеэгийн далд халдварын эмчилгээнд 15 иргэн хамрагдаж байна. Сүрьеэ, БЗДХ-ын илрүүлэг, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогчидтой хамтран аймгийн хэмжээнд 6 сум, 5 төрийн байгууллагын нийт 280 орчим албан хаагч болон эрсдэлт бүлгийн 315 иргэдэд үзлэг, шинжилгээг зохион байгууллаа. Тус үзлэгийн үр дүнд зорилтот бүлгийн иргэдийн 82 хувь нь илрүүлэгт бүрэн хамрагдсан бөгөөд эмчилгээний хамрагдалт 100 хувьтай байна.	100
69	2.3.1.1.6 Хавдрын эсрэг-Хамтдаа арга хэмжээг зохион байгуулах	80.0		48	50	Эрүүл мэндийн яам, Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ), Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ), Өргөө амаржих газар, Анагаахын шинжлэх ухааны их сургуультай (АШУУИС) хамтран зонхилон тохиолддог хавдрыг эрт илрүүлэх үзлэг,	100

					<p>оношилгоог зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Нийт 6466 иргэдийг хавдрын эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд хавдрын хяналтад нийт 992 хүн байгаагаас 2025 оны хагас жилийн байдлаар шинээр 68 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 59.6 хувь нь хавдрын эрт үедээ оношлогдсон нь оношилгооны чанар, хүртээмж сайжирч байгааг илтгэж байна. Мөн аймгийн хэмжээнд зорилтот бүлэгт хамаарах 45 ба түүнээс дээш насны нийт 25,528 иргэн байдгаас 14,136 иргэн буюу (46.3 %) -г урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд хамруулан ажиллаа.</p>		
<b>2.3.1.2 Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжиж, сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулна.</b>							
70	2.3.1.2.1. "Сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулах нь" арга хэмжээг зохион байгуулах	20.0		15.1	14.6	<p>Сэргийлж болох хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, АШУҮИС-ийн Хүүхдийн анагаахын тэнхимийн багш нартай хамтран хоёр удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 26 эрүүл мэндийн байгууллагын 148 эмч, мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Мөн Эрүүл мэндийн сайдын А/546 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд гэрийн эргэлтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр гурван</p>	100

						эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт, үнэлгээг хийж, шаардлагатай зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. 2025 оны хагас жилийн байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь 1000 амьд төрөлтөнд 11.9 промилтэй тэнцэж байна. Уг үзүүлэлт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор буюу 8.1 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	
71	2.3.1.2.2 "Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулах	20.0		13.9	12.9	2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс "Төрөх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дутуу төрөлтөөс сэргийлэх" бүсчилсэн сургалтыг урд болон зүүн бүсийн сумдад зохион байгууллаа. Тус сургалтаар өсвөр насны -175 охид, нөхөн үржихүйн насны-357, жирэмсэн-64, хөхүүл ээж-113 нийт-892 эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгов. Сургалтын дараа нийт-4 нярай, 7 жирэмсэн ээжийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдуулж зөвлөгөө өгч ажилласан. Хагас жилийн байдлаар нярайн эндэгдэл 2.3 промил болж өмнөх оны мөн үеэс 13.3 промилиэр буурсан үзүүлэлттэй байна.	100
<b>2.3.1.3 Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ.</b>							
72	2.3.1.3.1. Эрүүл аж төрөх арга зүйд иргэд, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, нээлттэй мэдээллийн танхим ажиллуулах	-		2200	2200	Монголын нэгдмэл анагаах ухааны нийгэмлэгээс нөлөөллийн баг бүрдүүлэн "Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай	100

						хослуулан хөгжүүлэх” сэдвийн хүрээнд бүсийн хэмжээнд хоёр удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд тогтмол зөвлөмж, мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд уг үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 1214 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдийг хамруулан ажиллаа.	
73	2.3.1.3.2. "Элэгний архаг үрэвсэл", "ЧШХШ-2" зэрэг халдварт бус өвчлөлийг УАУ-ны бие, хэл,сэтгэл засал хосолсон бүрэн цогц тусгай хөтөлбөрт эмчилгээг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэлэг бүтээгдэхүүн болгон хэрэгжүүлэх	-	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо, өссөн дүнгээр	40	80	Элэг цөсний өвчин болон чихрийн шижин хэвшинж II өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уламжлалт анагаах ухааны тусгай эмчилгээний хөтөлбөрийг боловсруулан 2025 оны 5 дугаар сарын 5, 8-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг хөтөлбөрт нийт 23 эмчлүүлэгчийг хамруулж, тусгай хоол эмчилгээний цэс боловсруулан, эмчлүүлэгчдэд хүргүүлж хэрэгжүүлсэн. Эмчилгээний явцад: Бие махбодыг хоргүйжүүлэх, хордлого тайлах, дархлаа дэмжих, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, цус шингэлэх, муу цус болон тамирын цусыг ялгах зорилгоор хануур засал зэрэг уламжлалт эмчилгээнүүдийг хийж гүйцэтгэсэн. Захын цусанд хийсэн шинжилгээгээр 7 хоногийн эмчилгээний хугацаанд цусан дахь сахарын хэмжээ дээд тал нь 5.0 ммоль/л-ээр буурч, эмчлүүлэгчдийн биеийн байдал сайжирсан.	70

						Эмчилгээний эрүүл зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, хөдөлгөөн заслын эмчилгээ зэргийг хавсран хэрэгжүүлснээр хүндрэл илэрсэн 4 өвчтөн (хөлөө тайруулсан, хумс хөхөрсөн, турж сульдсан зэрэг шинжтэй) нь хүндрэлээс урьдчилан сэргийлэх, зөв дадал зуршил төлөвшүүлэх үр дүнтэй эмчилгээ авсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнд нийт эмчилгээний үр дүн 94 хувьтай гарч, оношлогдсон өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, амьдралын чанарыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн байна.	
<b>2.3.1.4 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх</b>							
74	2.3.1.4.1 Бичил биетний эсрэг эмийн зарцуулалтыг хянах мэдээллийн санг үүсгэж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх	5.0	Мэдээллийн сан үүсгэсэн ЭМБ-ын хувь	0	30	Антибиотик мэдрэг чанар, тэсвэржилт, бичил биетний эмийн зарцуулалт, үүнээс тарилга эмэнд эзэлж буй хувь зэрэг мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэж эхэлсэн бөгөөд одоогоор 6 эрүүл мэндийн байгууллага мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2025 оны 4 дүгээр сарын байдлаар хэвтэн эмчлүүлэгсэд 7084, үүнээс антибиотик мэдрэг чанар 740 үйлчлүүлэгчид тодорхойлоход пенициллиний бүлэгт тэсвэржилт үүссэн 78.8% байна. Мөн бичил биетний эсрэг эмийн зарцуулалт 25.1 хувь байгаа бөгөөд нийт хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн 78% нь тарилгын хэлбэрээр байна.	50
<b>2.3.1.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх</b>							

75	2.3.1.6.1 Эмч эмнэлгийн мэргэжилтнийг өндөр хөгжилтэй оронд туршлага судлуулах, чадавхижуулах	20.0	туршлага судалсан эмч, эмнэлгийн ажилтны тоо	15	5	<p>Эмнэлгийн эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, олон улсын түвшний сургалт, туршлага солилцоонд хамруулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүллээ. БНСУ-ын Намъяанжу хотод байрлах "Эль (EL) эмнэлэг", Жолла мужийн Чон-Жу хотод байрлах "Хью Саранг эмнэлэг"-тэй 7 чиглэлээр хамтын ажиллагаа, солилцооны гэрээ байгуулж, харилцан туршлага солилцох, мэдлэг чадвар дээшлүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Гэрээний хүрээнд: Эрүүл мэндийн газар 1, Аймгийн нэгдсэн эмнэлэг 5, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг 1, нийт 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн 7–21 хоногийн богино хугацааны сургалтад хамрагдаж, эмчилгээ үйлчилгээний шинэ арга технологи, эмнэлгийн удирдлага, менежментийн талаар туршлага судалсан. Мөн төрийн санхүүжилтээр гадаадад суралцах хөтөлбөрийн хүрээнд сумын Эрүүл мэндийн төвийн 1 их эмч БНХАУ-ын Өвөр Монголын Олон Улсын Монгол эмнэлгийн хороонд 3 сарын сургалтад хамрагдсан. Нийт 8 эмч, мэргэжилтний буюу 2.2% нь хамрагдсан байна. Цаашид байгуулсан олон улсын гэрээ, санамж бичгийн дагуу эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, мэргэжилтнийг үе шаттайгаар богино хугацааны сургалт,</p>	90
----	---	------	--	----	---	---	----

						туршлага судлахад хамруулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэн зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	
76	2.3.1.6.2 Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд эмч, эмнэлгийн ажилтнуудыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах	60.0	арга хэмжээнд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо	0	8	Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажиллах болон амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаа. 20 сум, тосгоны хэмжээнд нийт 23 их эмч, 9 сувилагч, 1 бага эмчийг эмчийн байраар хангасан. Энэ нь хөдөө орон нутгийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж байна. 2025 оны хагас жилд Галшар, Биндэр, Норовлин сумдын Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон 3 их эмчийг эмчийн байраар хангаж, тухайн орон нутагт тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Бор-Өндөр суманд шинээр баригдаж буй орон сууцанд 2 эмчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах гэрээг орон нутгийн удирдлагатай байгуулсан. Цаашид эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг бүрдүүлэх, орон нутгийн хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор уг ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100

**2.3.1.7 Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж, барилга, автомашины хангалтыг нэмэгдүүлнэ.**

77	2.3.1.7.1 Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 8 хувиар нэмэгдүүлэх	800.0	Стандарт хангалтын хувь	55	57	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14-т Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгох заалтын хүрээнд ЭМЯамнаас орон нутагт 87.477.500 сая төгрөгийн санхүүжилтээр 25 ширхэг ECG S120 ухаалаг зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангасан. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 55.9% байна. Цаашид үлдсэн байгууллагуудыг шат дараатайгаар тоног төхөөрөмжөөр хангах, ашиглалт, сургалт, хяналтын механизмыг зэрэг хөгжүүлж, үндэсний тогтолцоог бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	100
78	2.3.1.7.2 Авто машин нэн шаардлагатай Эрүүл мэндийн байгууллагыг авто машинаар хангах	100.0	Автомашиннар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	30	1	Хагас жилийн байдлаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 93,8 сая төгрөгийн түргэн тусламжийн автомашиныг Ачманал ӨЭМТ, Биндэр, Батширээт сумын ЭМТөвүүдэд олгосон. Мөн Галшар, Баянхутаг, Батширээт СЭМТөвүүд түргэн тусламжийн автомашины засвар үйлчилгээнд 9,1 сая төгрөгийг тус тус зарцуулан ажилласан байна.	100
79	2.3.1.7.3 ЭМБ-уудын барилгын өргөтгөл, урсгал болон их засвар	4701.5	өргөтгөл, засвар хийгдсэн барилгын тоо	4	4	Хагас жилийн байдлаар шинээр ашиглалтад орсон эмнэлгийн барилга байгууламж байхгүй болно. Цэнхэрмандал, Бэрх сумын ЭМТөвүүдийн барилгын өргөтгөл, /ХэрлэнДОМ/	90

						жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлууд тус тус хийгдэж байна.	
<b>ЗОРИЛГО 2.4 ОРОН СУУЦ ДЭД БҮТЭЦ</b>							
<b>2.4.1. Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга байгууламжийн шаардлага хангасан барилгын тоог нэмэгдүүлж, нийтийн болон амины орон сууц барих санаачилгыг дэмжинэ.</b>							
<b>2.4.1.1. Төр хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн болон амины орон сууц барих санаачилгыг дэмжиж, түрээсийн орон сууцны сан бий болгоно.</b>							
80	2.4.1.1.1 Орон сууц барих санаачилгыг дэмжих	-	Ашиглалтад орсон сууцны айлын тоогоор	50	50	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Шинэ Өндөрхаан” хороололд 5 давхар 32, 48 айлын орон сууцыг тус тус байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Хэрлэн сумын 4-р багт байрлах “Хэнтий Стандарт” хорооллын 42 айлын орон сууц 90 хувийн гүйцэтгэлтэйгээр ажил явагдаж байна.	100
<b>2.4.1.2 Ногоон барилга, байгууламжийг нэмэгдүүлэхэд төр хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагааг хангаж ажиллана.</b>							
81	2.4.1.2.1 Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилга, барилгын материалын үйлдвэрлэл чиглэлээр аймагт үйлдвэрлэл эрхлэх ААН, иргэдийг дэмжих	700.0	Хамтарч ажилласан ААН, иргэдийн тоо, төсөл арга хэмжээний тоо	-	4	2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Аймгийн Засаг дарга болон холбогдох албаны хүмүүс барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн 40 орчим ААН-ийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулсан. Барилгын материал үйлдвэрлэгчдийн судалгааг хагас жилээр гаргаж Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн.	70
82	2.4.1.2.2 Төрийн байгууллагуудын барилга байгууламжид ногоон стандарт нэвтрүүлэх	450.0	Барилга байгууламжийн тоо	1	1	2025 онд шинээр баригдах барилга байгууламжийн 23 архитектур төлөвлөлтийн даалгавар, 11 ажлын зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулагдаж баталгаажсан. Тус даалгаварт “Ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагыг	70

						хэрэгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх” шаардлагыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн аймгийн 2025 оны ОНТөсвийн хөрөнгө оруулалтаар иргэдэд үйлчлэх “Хурдан” төвийн нарны толь суулгах, цахилгаан машины цэнэглэгч суурилуулах ажлын тендер зарлагдаж гүйцэтгэгч ажлаа эхлүүлэхэд бэлэн болсон. Мөн Дадал сумын цэцэрлэгийн барилгын эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр шийдсэн. 2025 оны 05 сарын 08-ны өдрийн аймгийн Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд 110 хүнд Монголын ногоон барилгын хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл оролцож Ногоон барилгын BESTGer үнэлгээний аргачлал, гэрчилгээжүүлэх журмын танилцуулга сургалтыг хийсэн.	
2.4.1.3 Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлттэй технологид суурилсан зураг төслийг дэмжиж ажиллана.							
83	2.4.1.3.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн ажлын зураг төсвийг боловсруулах даалгаварт ногоон барилга заалт оруулах	-	Зургийн даалгаврын тоо	3	+	2025 оны эхний хагас жилийн байдлаар шинээр баригдах барилга байгууламжийн 23 архитектур төлөвлөлтийн даалгавар, 11 ажлын зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулагдаж баталгаажсан. Эдгээр даалгаварт ногоон барилгын шаардлагыг хэрэгжүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх” шаардлагыг тусгаж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	90
2.4.1.4. Барилга байгууламжийн техникийн хяналт, барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг сайжруулж, барилга байгууламжийн чанарыг дээшлүүлнэ							

84	2.4.1.4.1. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн стандарт шаардлагыг хангасан байртай болох	650.0	-	-	байртай болсон байна.	Улсын төсвийн 750 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 395 м <sup>2</sup> барилгын материалын лабораторийн зориулалтаар байгууллагын өргөтгөлийн барилгын зураг төсөл батлагдан тендерт Хан багана ХХК шалгаран ажил эхлэхэд бэлэн болоод байна. Мөн Барилгын материалын лабораторийг 2,395,000 төгрөгийн үнэ бүхий олон үйлдэлт принтер-1ш, агаар цэвэршүүлэгч-2ш ширхэгийг тус тус авч тохижуулсан.	70
85	2.4.1.4.2. Захиалагчийн техник хяналтын үйл ажиллагаанд аудит хийх	-	Аудит хийсэн тоо	-	1	2024 оны улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажлуудад аудитын дүгнэлт гаргуулсан. Албан шаардлагын дагуу зөрчлийг арилгасан тайланг 2025 оны 06 сарын 09-ны өдөр 03/368 дугаартай албан тоотоор хүргүүлсэн.	100
86	2.4.1.4.3. Барилгачдын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах	10.0	Зөвлөгөөн зохион байгуулсан тоо	Зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулсан	+	Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2025.05.08-ны өдөр Бэрх тосгоны далд уурхайн музейн сургалтын танхимд зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд 110 аж ахуй нэгжийн төлөөллүүд оролцож, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Барилгын хөгжлийн төвийн дарга А.Пүрэвхатан болон аймгийн удирдлагууд оролцсон.	100
2.4.2. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон айл өрхийн тоог нэмэгдүүлнэ.							
2.4.2.1 Инженерийн шугам сүлжээний төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулж, найдвартай ажиллагааг хангана.							
87	2.4.2.1.1 Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэрлэн сум/, Гэр хорооллын инженерийн	Батлагдсан төсвийн хүрээнд	Гүйцэтгэлийн хувиар	30	50	Чингис хотын бохир усны төв коллекторын шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, Хэрлэн	100

	шугам сүлжээ /Хэрлэн сум, 1, 2, 3, 4, 5 дугаар баг/, Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Өмнөдэлгэр сум, Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламж /Жаргалтхаан сум/ төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад оруулж, хяналт тавьж ажиллах					сумыг гэр хорооллын ИШС-ний ажлын гүйцэтгэл 64%, Өмнөдэлгэр, Жаргалтхаан сумдын Цэвэрлэх байгууламж, шугам сүлжээний ажлын гүйцэтгэл 70%-тай үргэлжилж байна.	
88	2.4.2.1.2 Ашиглалтад орсон ИШС-ний ажил болон 15 сум, тосгоны цэвэрлэх байгууламжийн байнгын ашиглалтыг хангаж хариуцагч ажилчдыг сургалтад хамруулж, мэргэжлийн сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	5.0	Сургалт, зөвлөгөөнд хамрагдсан ажилчдын тоо	нийт 70 хүний бүрэлдэхүүнтэй сургалт зөвлөгөөн зохион байгуулсан.	70	Хэнтий аймагт дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, инженер техникийн ажилтан, галч нарт хийх “Аюулгүй ажиллагаа 2025 сургалт” 2025 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Биндэр суманд зохион байгуулж, Сургалтад Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 17 аж ахуйн нэгж байгууллагын усан халаалтын зуухны удирдлага, инженер, слесарь, машинист зэрэг нийт 103 албан хаагчид сургалтад хамрагдав.	100
89	2.4.2.1.3 Инженерийн шугам сүлжээнд холбогдсон жишиг гудамж байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	ИШС-нд нэмж холбогдсон айл өрхийн тоо	75	26	Хэрлэн сумын айл өрхийг ИШС-д холбох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, ИШС-д холбох ажлын урьдчилсан тооцоо судалгааг гаргасан. Тус үйл ажиллагаатай холбоотой батлагдсан төсөв байхгүй байна.	30
90	2.4.2.1.4 Сумдын инженерийн шугам сүлжээний байнгын үйл ажиллагааг сайжруулах техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Техник, тоног төхөөрөмжийн тоо	-	1	Биндэр сумын халаалтын зуухны тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажлын гэрээ байгуулагдаж тоног төхөөрөмжийн татан авалт хийгдэж байна.	90

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

ЗОРИЛГО 3.1 ТӨСӨВ САНХҮҮ

3.1.1 Татвар төлөгчийн бүртгэлийг бүртгэлийн байгууллагуудтай хамтран бодит цагийн горимоор бүртгэж, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх

91	3.1.1.1 Шинээр бүртгэгдэж байгаа хөрөнгийн татвар төлөгчдийг тухай бүр бүртгэж, цахим төлбөрийн баримтын системд холбох	-	Шинээр бүртгүүлсэн татвар төлөгчийн тоо	Хуулийн этгээдийн бүртгэлд 608 ААН, Цагдаагийн газрын бүртгэлийн мэдээллээр 98 галт зэвсэг, АТҮТ-ийн бүртгэлийг үндэслэн 2062 тээврийн хэрэгсэл, НӨАТ төлөгчөөр 165 ААН	Шинээр бүртгэвэл зохих татвар төлөгчдийг 63 хувиас доошгүй бүртгэж авах	<p>1.Хуулийн этгээдийн бүртгэлд шинээр 116 татвар төлөгчийг бүртгэн авч бүртгэгдвэл зохих хуулийн этгээдийг 100 хувь бүртгэсэн.</p> <p>2.Цагдаагийн газарт бүртгэлтэй галт зэвсгийн татвар төлөгчийг бүртгэлийг тулгаж, цэгцлэн 38 татвар төлөгчийг шинээр бүртгэн авч өмнөх онд 822 байсан бол 860 болж татвар төлөгчийн тоо 4 хувиар нэмэгдсэн. Орон нутгийн төсөвт эхний хагас жилд 13.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 6 сарын 18 ны байдлаар 13.8 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 99 хувиар биелүүлсэн.</p> <p>3.Автотээврийн газартай хамтран АЗД-ын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд улсын үзлэг тооллогыг явуулж үзлэгт хамрагдвал зохих 21926 тээврийн хэрэгслийг хамруулахаас 11517 тээврийн хэрэгслийг буюу 52 хувийг хамруулж, орон нутгийн төсөвт 540.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 524.3 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 96 хувиар биелүүлсэн. Олон жилийн өртэй 1964 тээврийн хэрэгслийн татвар төлөгчийн 148.7 сая төгрөгийн өрийг төлүүлсэн.</p> <p>4.НӨАТ төлөгчөөр бүртгэгдвэл зохих 28 татвар төлөгчийг бүртгэн авч, хуулийн дагуу 1 татвар төлөгчийг бүртгэлээс хасч НӨАТ төлөгчийн тоог өмнөх онд 661 байсан бол 688 болж 1 хувиар нэмэгдүүлсэн.</p>	91,96
----	---	---	---	---	---	--	-------

3.1.2 Бүх төрлийн татварын тайланг цахимжуулах

92	3.1.2.1 ТУНС-ийн мэдээлэлд үндэслэн татвар төлөгчид тайлан илгээхэд хялбар болгох системийн шинэчлэл хийх	-	Тайлан хүлээн авалтын хувь	90	91	Эхний хагас жилд бүх төрлийн татварын тайлангуудыг 99.2 хувиар хянаж хүлээн авч баталгаажуулсан.	99.2
<b>3.1.3 Хуульд заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу төлсөн татварыг буцаан олгох, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийг олгоно.</b>							
93	3.1.3.1 Хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголтод хамрагдах хуулийн заалт, тавигдах шаардлагыг бүрэн хангасан татвар төлөгчдийг хамруулах	-	Хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголтод хамрагдсан татвар төлөгчийн хувь	2023 онд ААНОАТ-ын тухай хуулиар 42 хуулийн этгээд, НӨАТ-ын тухай хуулиар 73 хуулийн этгээд, ХХОАТ-ын тухай хуулиар 13824 иргэн хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан	100	ААНОАТ-ын тухай хуулийн 22.3 дах заалтын дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хүсэлт гаргасан 38 ААН-ийн тайланг хянаж баталгаажуулан шалгуур хангасан 36 ААН-д 420,9 сая төгрөгийн татварыг буцаан олгосон. 2.ХХОАТ-ын тухай хуульд заасны дагуу 2024 оны орон сууц, сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргасан 1023 иргэний тайланг шалгаж хүлээн авч баталгаажуулан 1417,9 сая төгрөгийг төрийн сангаар дамжуулан буцаан олгосон.	100
<b>3.1.4 Шилэн дансны цахим хуудсаар байгууллагын төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.</b>							
94	3.1.4.1 Байгууллагын төсөв, санхүү, хүний нөөц, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах	-	цахим системд байршуулсан мэдээллийн хувиар	92	94	Хэнтий аймгийн 2024 оны жилийн эцсийн Шилэн дансанд бүртгэлтэй Засаг даргын дэргэдэх агентлаг, аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, захирагчийн ажлын алба, Төсвийн төвлөрүүлэн захирагч, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, Ойн анги нийт 187 байгууллагын оруулбал зохих нийт 33109 мэдээллээс, оруулсан 32753, хугацаандаа 32310, хугацаа хоцроосон 264, мэдээллийг огт байршуулаагүй 757 байна.	97.6
<b>3.1.5 Санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж, дотоод хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны зөрчлийг бууруулна.</b>							
95	3.1.5.1 Санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулж,	14.9	Эрсдэлийн хувь	Санхүүгийн хяналт	12	2025 оны эхний хагас жилд 24 байгууллагын үйл ажиллагаанд	95

	<p>дотоод хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны зөрчлийг бууруулах</p>			<p>шалгалтаар 15 хувь нь дунд болон их эрсдэлтэй үнэлэгдсэн байна.</p>		<p>санхүүгийн хяналт шалгалт хийхээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелсэн. Тухайлбал Сангийн сайдын 01 тоот нэгдсэн удирдамжаар аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд, түүнчлэн аймгийн Засаг даргын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн 2023-2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Шалгалтаар илэрсэн зөрчлийг ангилвал: Нийт зөрчлийн 40 хувь буюу 6399.9 сая төгрөг нь өглөгтэй илэрхийлэгдсэн, 22 хувь буюу 3565.8 сая төгрөг нь анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, 21.9 хувь буюу 3451.4 сая төгрөг нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлж ажиллаагүй, 14 хувь буюу 2197.1 сая төгрөг нь зориулалт бусаар зарцуулсан /эдийн засгийн ангилал буруу, холбогдох дээд шатны төсвийн захирагчийн захирамж шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл авсан зэрэг/, 0.8 хувь буюу 118.4 сая төгрөг нь илүү олгосон цалин хөлс, 0.3 хувь буюу 5.4 сая төгрөг нь данс бүртгэлдээ тусгаагүй зөрчил тус тус эзэлж байна. Шалгалтаар нийт 15743.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 16.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр улсын байцаагчийн акт, 13563.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох,</p>	
--	--	--	--	--	--	---	--

						цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага тус тус тогтоов.	
<b>3.1.6 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн эргэн төлөлтийг сайжруулан, жижиг дунд бичил бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ</b>							
96	3.1.6.1 Зээл олгож байгаа албан хаагчдад сургалт зохион байгуулж чадавхийг нэмэгдүүлж, төрийн сангийн дотоод хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах	42.0	Сургалт зохион байгуулсан тоо	1	2 удаа	Жаргалтхаан, Цэнхэрмандал, Мөрөн, Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Хэрлэнбаян Улаан, Гурванбаян, Өлзийт тосгодын Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт, 2024 оны зээлийн үлдэгдэл 1178.9 сая төгрөгт хяналт шалгалтыг хийж зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, шат дараатай арга хэмжээг яаралтай авч ажиллах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн сумдын ХХСан хариуцсан мэргэжилтэнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх, хяналт тавих журам” -ын хэрэгжилтийг ханган ажиллах, зээлдэгчдэд сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах, ХХСангийн Хороо, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлж, сайжруулан ажиллах талаар зөвлөмж, зөвлөгөөг газар дээр нь өгч ажилласан.	100
97	3.1.6.2 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 50 хувиар нэмэгдүүлэх	20.2	Зээлийн эргэн төлөлтийн хувь	Хоршоо хөгжүүлэх сангийн нийт 5.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна	30%	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөр 2025 оны жилд 1,0 тэрбум төгрөгийн зээлийг барагдуулахаар төлөвлөснөөс эхний 6 сард 862,7 сая төгрөгийн авлагыг барагдуулахаас 520,8 сая төгрөгийн зээлийг төлүүлээд байна.	100
<b>3.1.7 Орон нутгийн өмчийн ашиглалт үр өгөөнжийг нэмэгдүүлэх</b>							
98	3.1.7.1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн	12,0	187 байгууллагын	187 байгууллагын	100	120 байгууллагын гэрээ дүгнэж баталгаажуулж, хяналт,	100

	оролцоотой байгууллагуудын гэрээг жил бүр бүрэн дүгнэж, гэрээ байгуулж, эд хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах		гэрээг дүгнэсэн хувиар	гэрээ дүгнэж баталгаажуулсан.		шалтгалтын ажлыг зохион байгуулсан байна.	
<b>3.1.8 Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны тоог нэмэгдүүлж, худалдан авах ажиллагааг ил тод байлгана.</b>							
99	3.1.8.1 Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой бараа, бүтээгдэхүүнийг хэрхэн тендерийн баримт бичигт оруулах талаар төсвийн байгууллагуудад сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан байгууллага, албан хаагчын тоо	-	150	2025 оны хагас жилийн байдлаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 153 хүн сургалтад хамрагдсан.	100
100	3.1.8.2 Аймгийн хэмжээнд зарлагдсан төсөл арга хэмжээнд дотоодод үйлдвэрлэсэн барааны нэр төрөл, үнийн дүнг тусгах	-	Тусгагдсан үнийн дүн	484,0	600,0	Худалдан авах ажиллагааны газраас зарласан 48 төсөл арга хэмжээнд хуулийн 8 дугаар зүйл дотоодын үйлдвэрлэлийг дэмжих давуу эрх тооцох талаар тендерийн баримт бичигт тусгаж оруулсан. Үүний дагуу “Нэгдсэн эмнэлгийн гадна фасадны засвар”-ын ажилын тендер шалгаруулалтад шаардлагыг хангасан нэг оролцогчид давуу эрх тооцож олгосон ба тендерт шалгаруулалтын төсөвт өртөг 829,0 сая төгрөг.	100
101	3.1.8.3 Худалдан авах ажиллагааны шалгалтыг зохион байгуулж анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлэх	-	Мэргэшүүлэх шалгалтанд тэнцсэн хүний тоогоор	216,0	35-аас дээш	2025 оны хагас жилийн байдлаар 4 удаа А3 сертификат олгох шалгалт зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд А3 гэрчилгээ бүхий 277 төрийн албан хаагч, иргэн, иргэний нийгмийн төлөөлөл байна.	100
<b>3.2. ТӨРӨЛЖСӨН ЭДИЙН ЗАСАГ</b>							
<b>3.2.1. Уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах хүнд үйлдвэрийн төслүүдийг дэмжиж ажиллана.</b>							
<b>3.2.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Бор-Өндөр суманд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ.</b>							

102	3.2.1.1.1 Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах төслийг дэмжиж, хамтран ажиллах	-	Дэмжиж, хамтран ажилласан эсэх	-	+	Бор-Өндөр үйлдвэрлэл технологийн паркийн төслийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс ҮТП” ХХК-тай Хэнтий аймгийн Засаг дарга хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Уг парк бүрэн утгаараа ажиллаж эхэлснээр Бор-Өндөр сумын дотоодын нийт бүтээгдэхүүн найм дахин, Хэнтий аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 4.2 дахин өсөх, 7000 гаруй ажлын байр шинээр бий болох, эдийн засаг, стратегийн томоохон хот болж хөгжих юм. Паркын газрын байршлыг сонгож сумын ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгасан. 6 сард аймгийн ИТХ-аар тус газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Үндсэн үйлдвэрүүдийн ТЭЗҮ-үүд эхнээсээ хийгдээд явж байна. Хамгийн гол бичиг баримт болох 2035 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө бэлэн болсон.	100
103	3.2.1.1.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын эрдэс түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих		Дэмжиж, хамтран ажилласан эсэх	-	+	II-III	ХБТХОХ
3.2.2. Зорчигч иргэдийг тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.							
3.2.2.1. Хот хооронд болон хот доторх зорчигч тээврийн болон авто үйлчилгээ эрхлэгчдийг стандартын шаардлага хангуулна.							
104	3.2.2.1.1 Зүүн бүсийн шуудан логикийн төв байгуулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Гүйцэтгэлийн хувиар	-	25	“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн зүүн бүсийн чуулган 2025” зохион байгуулагдах үеэр аймгийн Засаг дарга Монгол шуудан ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд “Зүүн бүсийн шуудан логикийн төв” байгуулах ажлын хүрээнд тус төвийг байгуулахад шаардлагатай 5 га газрыг Мөрөн сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулан	30

						сумын ИТХ-аар оруулан шийдвэрлүүлсэн.	
105	3.2.2.1.2 Хот доторхи такси үйлчилгээ эрхлэгч нарыг бүртгэлжүүлэх	-	Бүртгэлжүүлэх ажлын хэрэгжилтийн хувиар	-	30	Хэнтий аймгийн 18 сум 5 тосгонд орон нутгийн тээвэр, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн судалгаа хийгдэж байна. Чингис хотод хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй UB cab үйлчилгээнд бүртгэлтэй 100 орчим иргэн байгаагаас 30 такси идэвхтэй үйлчилгээ үзүүлж байна.	70
<b>3.2.2.2. Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана</b>							
106	3.2.2.2.1 Улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлын батлагдсан норм дүрмийг мөрдлөг болгож гүйцэтгэх	-	Гүйцэтгэлийн хувиар	-	100	Нийт 493 км улсын чанартай аюто замын засвар, арчлалтын ажил хагас жилийн байдлаар 73%-тай үргэлжилж байна.	100
107	3.2.2.2.2 Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалтын ажлын батлагдсан норм дүрмийг мөрдлөг болгож гүйцэтгэх	Батлагдсан төсвийн хүрээнд	Гүйцэтгэлийн хувиар	-	100	Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх авто замын засварын ажлын гүйцэтгэгч шалгарч ажлаа эхэлсэн.	70
<b>3.2.3. Хэрэглэгчдийг чанартай, найдвартай дулаан хангамж, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангаж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.</b>							
<b>3.2.3.1. Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн инженерийн шугам сүлжээний ажлын өргөтгөлийг гүйцэтгүүлж, дулааны станцын 17ш ДДТ-ийн ИШС-ний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттайгаар ашиглалтад оруулна.</b>							
108	3.2.3.1.1 Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах	16296.14	Гүйцэтгэлийн хувиар	-	30	Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдсан.	50
109	3.2.3.1.2 Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах	8143.8	Гүйцэтгэлийн хувиар	30	70	Дулааны станцын гадна цахилгаан хангамжийн ажил 30%-тай үргэлжилж байна.	50
<b>3.2.3.2. Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220кВ-ын 518 км цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлыг эхлүүлнэ</b>							
110	3.2.3.2.1 Холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	-	Дэмжлэг үзүүлсэн эсэх	Суурь судалгаа хийгдэж, ТЭЗҮ боловсруулагдсан.	хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхэд орон нутгаас шаардлагат	Эхний хагас жилийн байдлаар дээрх төслийг хэрэгжүүлэх талаар албан бичиг болон хүсэлт ирээгүй.	*

					ай дэмжлэг үзүүлэх		
<b>3.2.3.3. Нар, салхины сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшил, оролцоотойгоор хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</b>							
111	3.2.3.3.1 Хэрлэн суманд 30 мВА чадалтай батерей хуримтлууртай нарны сэргээгдэх эрчим хүчний зураг төслийг боловсруулах.	200.0	Гүйцэтгэлийн хувиар	Холбогдох суурь судалгаа хийсэн.	30%	Хэрлэн суманд 30 мВА чадалтай батерей хуримтлууртай сэргээгдэх эрчим хүчний төслийн ТЭЗҮ боловсруулагдсан ба барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил үргэлжилж байна.	50
112	3.2.3.3.2 Шинээр баригдах барилга байгууламжид ЦЭХ-ний техникийн нөхцөл олгоходоо нөөц үүсгүүрийг сэргээгдэх эрчим хүчээр шийдэх талаар тусгах.		Барилгын тоо	-	2	Эхний хагас жилийн байдлаар 78 удаагийн техникийн нөхцөл олгосон ба үүнээс 2 объектод ЦЭХ-ний нөөц үүсгүүрийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр төлөвлөхийг тусгасан болно.	100
<b>3.2.4. "Шинэ хоршоо", "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хүртээмжийг нэмэгдүүлнэ.</b>							
<b>3.2.4.1. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх хоршоодыг нэмэгдүүлэн, дундын хоршоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.</b>							
113	3.2.4.1.1. Хоршоодыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, сайн туршлагыг сурталчлах	5.0	Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоогоор	2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 468 хоршоо шинээр байгуулагдаж Засгийн газар, Хөгжлийн шийдэл ТББ, ХААХХолбоотой хамтран 8 сургалт зөвлөгөөн зохион байгуулан давхардсан тоогоор 120 хоршооны 380 гаруй хоршоологчид хамрагдсан	2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулж 100-аас доошгүй хоршооны гишүүдийг хамруулна.	Монгол Улсын Шадар сайд, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны дарга С.Амарсайханы 2025 оны 32 дугаар тушаалын хүрээнд Хэнтий аймгийн Чингис хотноо 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Хэнтий аймгийн "Хоршоологчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 18 сумын 360 гаруй малчин, хоршоологч, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд оролцсон. Мөн 5 сумын малчид, хоршоологчдын зөвлөгөөн, хөдөлмөр халамжийн төслийн нээлтийн арга хэмжээнд оролцож 6 удаагийн сургалтад 900 гаруй иргэнд Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтийг сурталчилан таниулсан.	100
114	3.2.4.1.2. Хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамруулах.	-	Зээл авсан хоршоодын тоогоор	2024 онд ХХС-аас 14 хоршоонд	10-с доошгүй хоршоонд	Хоршоо хөгжүүлэх сангаас хүнс боловсруулахад 2 хоршоонд 60.0 сая, ахуйн үйлчилгээ эрхлэхэд 2	100

				604.7 сая төгрөгийн зээл олгосон.	зээлийн дэмжлэг үзүүлнэ	хоршоонд 128.3 сая, мал аж ахуй, эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэхэд 3 хоршоонд 202.4 сая, газар тариалан эрхлэхэд 1 хоршоонд 80.0 сая, мал төхөөрөх үйлдвэр байгуулахад 80.0 сая нийт 9 хоршоонд 550,7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 54 ажлын байр хадгалагдаж, 19 ажлын байр шинээр нэмэгдсэн.	
115	3.2.4.1.3. Хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв байгуулж, үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.	32.5	гүйцэтгэлийн хувиар, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоогоор	-	Ашиглалтад орсон байна.	Хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв байгуулахаар хуучин барилгын засварын ажлыг 7-р сард хийхээр төлөвлөсөн. Хугацаа болоогүй байна.	Х/Б
<b>3.2.4.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.</b>							
116	3.2.4.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	-	Хөнгөлөлттэй зээл олгосон тоогоор	Анхан шатны 5 үйлдвэр байгуулахад ХХС-аас 338.7 сая төгрөгийн зээл олгосон.	1-с доошгүй анхан шатны үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгоно.	Малын гаралтай түүхий эд боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулах чиглэлээр Батноров сумын "Хүрдэтийн гурван бүрд" хоршоо 80,0 сая, Норовлин сумын "Цохонд" хоршоонд 30,0 сая нийт 110,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	100
117	3.2.4.2.2. Гарааны бизнес эрхлэгчдийг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубатор төвүүдээр бойжуулж, дэмжлэг үзүүлнэ.	-	Бойжсон болон дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор	11 гарааны бизнес эрхлэгчдэд 99.5 сая төгрөгийн зээл олгосон. Хөдөө аж ахуйн дэмжих төвөөр 12 иргэн аж ахуйн нэгж бойжиж байна.	5 доошгүй иргэд, аж ахуйн нэгжийг бойжуулсан байна	Хоршоо, жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвд 2 аж ахуйг нэгжийг бойжуулан 11 иргэнийг ажлын байраар хангаад байна.	70
118	3.2.4.2.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцож, туршлага судлуулахад дэмжлэг үзүүлэх	2.5	Туршлага судалж оролцсон арга хэмжээний тоогоор	6 арга хэмжээнд 105 жижиг дунд үйлдвэрлэгчид оролцсон.	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг 2-с доошгүй арга хэмжээнд оролцуулж,	Дотоодын 4 удаагийн үзэсгэлэн худалдаанд 237 жижиг үйлдэрлэл эрхлэгчдийг оролцуулсан. "Бизнесээ томруулъя" жижиг, дунд бизнес эрхлэгчдийн чуулга уулзалтад 3 аж ахуйн нэгжийг хамруулсан.	100

					туршлага судлуулна.		
<b>3.2.4.3. Ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулж, үйлчилгээний салбарт ажиллагсдыг чадавхжуулна.</b>							
119	3.2.4.3.1. Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх.	-	Гүйцэтгэлийн хувиар	-	10	Малын гаралтай түүхий эд боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулах чиглэлээр Батноров сумын "Хүрдэтийн гурван бүрд" хоршоо 80,0 сая, Норовлин сумын "Цохонд" хоршоонд 30,0 сая нийт 110,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	100
120	3.2.4.3.2. "Ахуйн үйлчилгээ" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах.	10.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	"Ахуй үйлчилгээний өдөрлөг", "Зүүн бүсийн үсчин гоо засалчдын тэмцээн"-ийг зохион байгуулсан	1	"Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн зүүн бүсийн анхдугаар чуулган хэлэлцүүлэг"-ийг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Чингис хотноо зохион байгуулж, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн 230 гаруй ахуйн үйлчилгээний салбарын ажиллагсдыг хамруулсан.	100
<b>3.2.5. "Атар IV" аян, "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.</b>							
<b>3.2.5.1. "Атар IV" аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.</b>							
121	3.2.5.1.1. Хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох, тариалангийн бүс нутагт хяналт шалгалтаар ажиллах	2.0	Хяналт хийсэн сумдын тоогоор	9 сумын 35 аж ахуйн нэгжийн 19 мян.гад хяналт шалгалт хийсэн.	10-с доошгүй сумдад ажилласан байна.	2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд улаан буудайн 12310 га, төмс 141 га, хүнсний ногоо 162.5 га, бусад үр тариа 6635 га, ногоон тэжээл 490 га, тосны ургамал 7428 га, эмийн ургамал 100 га талбайд тус тус тариалалт хийгдэж, төлөвлөгөөт тариалалт 78.3%-тай явагдаж байна. Иймд хаврын тариалалт дуусаагүй байгаа тул соёлолтын чанарт хийгдэх хяналт шалгалт 06 дугаар сарын 25-наас хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хугацаа болоогүй.	Х/Б
122	3.2.5.1.2. Атаршсан 5.0 мянган га талбайг эргэлтэд оруулах.	-	эргэлтэд оруулсан талбайн хэмжээ га	2987 га тариалангийн талбайг эргэлтэд оруулсан.	1250 га-гаас доошгүй атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулна.	Монгол Улсын Засгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний 166 дугаар тогтоолоор тус аймгийн 4 сумын 2130.2 га атар газрыг тариалангийн талбайд шилжүүлсэн.	100

123	3.2.5.1.3. Тариалангийн талбайн хөрс хамгаалах тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх	-	нэвтрүүлсэн Га-гаар	50га-д тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлсэн	100 га-д нэвтрүүлсэн байна.	Тариалангийн талбайн хөрс хамгаалах тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх зорилгоор Хэрлэн сумын "Хэнтий тариалан" ХХК нь 200 га-д улаанбуудай, арвайн холимог тариалалт хийсэн.	100
124	3.2.5.1.4. Тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах	-	Үр тарианы хамгаалалтын ойн зурвас байгуулсан га-аар	Нийт 13.6 га тариалангийн талбайд зурвас байгуулсан.	100 га-д хамгаалалтын зурвас байгуулсан байна.	Тариалангийн талбайн хөрс хамгаалах тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх зорилгоор Хэрлэн сумын "Хэнтий тариалан" ХХК нь 200 га-д улаанбуудай, арвайн холимог тариалалт хийсэн.	100
125	3.2.5.1.5. Хоршоо, иргэн, аж ахуйн нэгж, ногоочдод хөнгөлөлттэй үрийн дэмжлэг үзүүлэх	15.0	дэмжлэг үзүүлсэн хоршоо, иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор.	750 иргэн, аж ахуйн нэгжид 8 нэр төрлийн төмс, хүнсний ногооны 21.2 тн хөнгөлөлттэй үрийн дэмжлэг үзүүлсэн.	750-аас багагүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 04-ний А/688 тушаалаар 80 хувийн хөнгөлөлттэй 9000 кг төмсний үрийн 5 сумын 29 ногоочинд олгосон. Мөн Усалгаатай хөдөө аж ахуй төслийн хүрээнд 8 сумын 56 ногоочин 100 кг 6 төрлийн ногооны үрийн дэмжлэгийг үнэгүй олгосон.	50
126	3.2.5.1.6. Хэрлэн суманд услалтын систем шинээр байгуулах.	-	Гүйцэтгэлийн хувиар	Услалтын системийн барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	Услалтын системийн барилга угсралтын ажил 90 хувьд хүргэсэн байна.	Услалтын системийн барилга угсралтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	90
127	3.2.5.1.7. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	-	дэмжлэг үзүүлсэн тоогоор	36 зуны хүлэмж ашиглалтад орсон.	Өвөл зуны хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Бор-Өндөр суманд ХХСангаас нэг аж ахуйн нэгжид өвлийн хүлэмж байгуулах чиглэлээр 80 сая төгрөгний зээл олгосон. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн суманд 3 ширхэг, Мөрөн суманд 1 ширхэг, Батширээт суманд 1 ширхэг буюу 6*20 харьцаатай 120 м2, 5 ширхэг хүлэмжийг тус тус олгоод байна.	100

128	3.2.5.1.8. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт, зөвлөгөөн зохион байгуулах.	7.0	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	Улсын болон аймгийн хэмжээний анхан шатны сургалтад давхардсан тоогоор 120 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.	100-аас доошгүй тариалан эрхлэгчдийг сургалт, зөвлөгөөнд хамруулсан байна.	ОНТөсвийн 7.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Бүсчилсэн хөгжил-Тогтвортой газар тариалан 2025” тариаланчдын нэгдсэн зөвлөгөөн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, Дорнод, Сүхбаатар болон 18 сумын 2 тосгоны 160 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон.	100
129	3.2.5.1.9. Сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтний чадавхи сайжруулах сургалт зохион байгуулах.	4.0	Сургалтад хамрагдсан хүний тоогоор	30 мэргэжилтэн хамрагдсан	36	2025.05.08-ны өдөр "Сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтнийг чадавхижуулах сургалт, зөвлөгөөн"-ийг 4.0 сая төгрөгний санхүүжилтээр зохион байгуулж, 16 сум, 5 тосгоны нийт 46 албан хаагчид тус зөвлөгөөнд оролцсон.	100
<b>3.2.5.2. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аюулгүй, чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.</b>							
